



ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН  
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын Хөрөнгө гаргах тухай 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/32 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас зарласан Хагийн хар нуур руу чиглэсэн маршрут мэдээллийн самбар, тэмдэгжүүлэлт ГТБЦГХЗ/202004002 тоот цахим тендерт хамгийн сайн үнэлэгдсэн "Улаанбаатар аялал жуулчлалын холбоо" ТББ-аар модон хаалга, мэдээллийн самбар бариулах ажлыг зохион байгуулан ажиллахыг Аялал жуулчлал, сургалт сурталчилгаа, гадаад хамтын ажиллагаа, орчны бүс хариуцсан мэргэжилтэн /Ө.Уянга/-д даалгасугай.
2. Хагийн хар нуур руу чиглэсэн маршрут мэдээллийн самбар, тэмдэгжүүлэлтийн ажлын зардал 14.700.000 /Арван дөрвөн сая долоон зуун мянган/ төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын Хөрөнгө гаргах тухай 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/32 дугаар тушаалаар эрх олгосон зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Гандолгор/-т зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлыг зохион байгуулан тайлагнахыг хамгаалалтын захиргааны даргын 2020 оны 05 дугаар сарын 22-ны А/23 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч, ахлах мэргэжилтэн /С.Бэлэгсайхан/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ДУЛАМСҮРЭН